



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 36

Хэрлэн сум

Сонгон шалгаруулалтын комисс
байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.2.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.3, 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 3.1, 3.3, 3.4-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Баярсайхан Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Ш.Эрдэнэжаргал Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Ч.Эрдэнэбаатар Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Аудитын газрын дарга
С.Бат-Эрдэнэ Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дарга
Д.Өнөрцэцэг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

2. Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, дүнг танилцуулахыг шалгалтын комиссын дарга / Б.Баярсайхан /-д даалгасугай.

3. Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын тайлан, судалгааг хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР